

ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭНИЙН
МОНГОЛ УЛСЫН ӨМНӨД БҮСИЙН ДЭД БҮТЦИЙН СТРАТЕГИ, УУЛ
УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ДЭМЖИХ ТЭЭВЭР, ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ
СЕМИНАРТ ХЭЛЭХ ҮГ

2008 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр

Эрхэм хүндэт зочид төлөөлөгчид өө,

Ноёд хатагтай нараа,

Энэхүү семинарт хүрэлцэн ирсэн Та бүгдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая.

Монгол Улсын өмнөд бүс нутаг, тухайлбал Өмнөговь аймагт илэрсэн орд газруудыг ашиглахтай холбоотой уул уурхайн үйл ажиллагааг дэмжих зорилгоор тээвэр, эрчим хүчний зохицуулалтын талаар зохион байгуулагдаж байгаа энэхүү семинар нь цаг үеэ олсон, тээврийн дэд бүтцийг, тухайлбал төмөр зам болон авто замыг байгуулах асуудал яригдаж байгаа өнөө үед зайлшгүй шийдвэрлэвэл зохих асуудлын нэг яах аргагүй мөн билээ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжил, ялангуяа эдийн засгийн гадаад харилцааг хөгжүүлэх, экспортын зах зээлийг өргөтгөхөд ашигт малтмалын орд газруудыг эзэмших, олборлох асуудал ихээхэн чухал бөгөөд үүнтэй холбогдуулан ашигт малтмалыг тээвэрлэх асуудал, тухайлбал тээврийн дэд бүтцийг бий болгох, ийнд: төмөр замын сүлжээг бий болгох, авто замыг барих чиглэлээр Засгийн газраас ихээхэн анхааран ажиллаж байна.

Энэ хүрээнд Говийн бүсийн төмөр замын сүлжээний хэсэг буюу Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Ухаа худагийн нүүрсний орд газраас Гашуун сухайтын чиглэлд төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Энержи ресурс”ХХК-д, мөн Гурвантэс сумын нутагт байрлах Нарийн сухайтын нүүрсний орд газраас Шивээ хүрэнгийн хилийн боомт хүртэл 47,5 км төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Монголын алт”ХХК-д тус тус олгоод байгаа бөгөөд одоогоор эдгээр компаниуд төмөр замын техник-эдийн засгийн нарийвчилсан үнэлгээ хийх чиглэлээр ажиллаж байна.

Цаашид энэ бүс нутагт төмөр замын болон авто замын сүлжээг барих, ашиглах тал дээр төрийн болон хувийн хамтын ажиллагааны онцлог, олон улсын туршлага, тухайлбал уул уурхай хөгжсөн өндөр хөгжилтэй орнуудад ашиглагдаж байгаа хамтын ажиллагааны хэлбэр, гэрээ, хэлэлцээрүүдийг судлах бололцоо олгох, манай оронд тохирох хувилбарыг сонгон авахад энэхүү семинараар хэлэлцэгдэх асуудал ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

олгох, манай оронд тохирох хувилбарыг сонгон авахад энэхүү семинараар хэлэлцэгдэх асуудал ихээхэн ач холбогдолтой гэж үзэж байна.

Говийн бүсийн төмөр зам болон автозамын сүлжээ бий болсноор тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх, ялангуяа Ази–Европыг холбосон тээврийн дөт замыг бий болгох, гадаад худалдаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, дамжин өнгөрөх тээврийг зохион байгуулах, тээврийн цогц ийлчилгээг сүлжээний дагуу тээвэрлэгч, ийлчлүүлэгчдэд хиргэх боломжтой юм.

Энэ чиглэлээр бусад орнуудад ашиглагддаг эрх зүйн гэрээ, хэлэлцээр болон зохицуулалтыг судалж, тээврийн дэд бүтцийг бий болгоход хувийн хэвшлийн санаачлага, оролцоог дэмжин хөгжүүлэхэд ихээхэн анхаарах болно.

Семинарын үйл ажиллагаанд амжилт хүсч, Та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Анхаарал тавьсанд баярлалаа.